



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 07

Мандалговь

Мотоциклд үнэлгээ тогтоож, худалдах тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.9, 5.11 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сум дундын шүүхийн шийтгэх тогтоолоор орон нутгийн орлого болгохоор шийдвэрлэгдсэн мотоциклуудыг хавсралтын дагуу батлагдсан үнээр нь худалдан авах хүсэлт гаргасан хүнд худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Мотоциклуудыг батлагдсан үнийн дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд үүрэг болгосугай.

ДАРГА С. Сүхбаатар С. СҮХБААТАР



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны 08 сарын 03-ны өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт



Худалдах эд хөрөнгө

№	Эд хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Улсын дугаар	Марк	Өнгө	Худалдах үнэ
1	Мотоцикль	1	дугааргүй	Мон-иж	хар	100,000
2	Мотоцикль	1	25-98 ДУЗ	Dayun	Улаан	150,000
3	Мотоцикл	1	Дугааргүй	Jian Ying	Улаан	150,000
4	Мотоцикл	1	Дугааргүй	Haojue	Мөнгөлөг	80,000
5	Мотоцикл	1	80-03 ДУЗ	HENSIM	улаан	50,000
ДҮН						530,000